



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/158

Сүхбаатар сум

Аймгийн Засаг даргын 2020 оны А/158 дугаар
захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “ж”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Улсын Онцгой комиссын 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхий нийтэд хурдацтай тархаж байгаа /COVID-19/-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор “Аймгийн Засаг даргын 2020 оны А/158 тоот захирамжийн 1 дэх заалтын “б дугаар сарын 30-ны” өдөр хүртэлх гэснийг өөрчилж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг “2020 оны 7 дугаар сарын 15-ны” өдрийг дуустал сунгасугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Энхбаатар/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ